

**БАНКНЫ САЛБАР БАЙГУУЛАХ  
ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ  
ТОГТООХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

**НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэ журмын зорилго Банкны тухай хуулийн 18 дугаар зүйл, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банканд Монгол Улсад болон гадаад улсад банкны салбар байгуулах зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Банкны салбар нь хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн үйл ажиллагааг эрхэлнэ.

1.3.Монголбанк банкны салбарын бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны чиглэл, хэмжээ, бүтэц, хүний нөөц, ажлын байр зэргийг харгалзан тусгайлан шаардлага тавьж, эрхлэх үйл ажиллагааг хязгаарлаж болно.

1.4.Монголбанк дотоодод банкны салбар байгуулах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаагаар олгоно.

1.5.Банкны салбар байгуулах зөвшөөрлийн хүрээнд банкны салбар шинээр байгуулах, банкны салбарын хаяг, байршлыг өөрчлөх тухай бүр тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Монголбанканд мэдэгдэнэ.

1.6.Банк гадаад улсад банкны салбар байгуулах тухай бүр Монголбанкнаас зөвшөөрөл авна.

1.7.Монголбанк энэ журмын 2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн банкны салбар байгуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгож болно.

**ХОЁР.БАНКНЫ САЛБАР БАЙГУУЛАХ  
ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

2.1.Монголбанк дараах шаардлагыг хангасан банканд Монгол Улсад салбар байгуулах зөвшөөрөл олгоно:

2.1.1.Банкны тухай хуулийн 16, 17 дугаар зүйл болон Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 6 сарын турш тогтмол хангаж ажилласан;

2.1.2.Монголбанкнаас хамгийн сүүлд хийгдсэн газар дээрх иж бүрэн шалгалтын үнэлгээ нь “Дунд” ба түүнээс дээш байх;

2.1.3.банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх тухай Монголбанкнаас баталсан журмын дагуу хамгийн сүүлд авсан зохистой засаглалын үнэлгээ нь “Дунд” ба түүнээс дээш байх.

2.2.Монголбанк дараах шаардлагыг хангасан дотоодын банканд гадаад улсад банкны салбар байгуулах зөвшөөрөл олгоно:

2.2.1.банкны үйл ажиллагааг сүүлийн 2-оос багагүй жилийн хугацаанд тогтвортой эрхэлсэн;

2.2.2.Банкны тухай хуулийн 16, 17 дугаар зүйл болон Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 12 сарын турш тогтмол хангаж ажилласан;

2.2.3.Монголбанкнаас хамгийн сүүлд хийгдсэн газар дээрх иж бүрэн шалгалтын үнэлгээ нь “Хэвийн” ба түүнээс дээш байх;

2.2.4.банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх тухай Монголбанкнаас баталсан журмын дагуу хамгийн сүүлд авсан зохистой засаглалын үнэлгээ нь “Дунд” ба түүнээс дээш байх;

2.2.5.тухайн банкны салбарт хяналт шалгалт хийх, бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ хэрэгжүүлэх боломжтой байх;

2.2.6.банк, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх.

2.3.Энэ журмын 2.2-т заасан зөвшөөрөл бүхий банкны салбарын үйл ажиллагааны нөхцөлийг Монголбанк тогтоож болно.

### **ГУРАВ.БАНКНЫ САЛБАР БАЙГУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

3.1.Банк Монгол Улсад банкны салбар байгуулах хүсэлтээ албан бичгээр Монголбанканд ирүүлнэ.

3.2.Банк гадаад улсад банкны салбар байгуулахад дараах баримт бичгийг Монголбанканд ирүүлж, зөвшөөрөл хүснэ:

3.2.1.банкны салбарын гадаад улсад эрхлэх үйл ажиллагааг тодорхой заасан, банкны салбар байгуулах албан хүсэлт;

3.2.2.гадаад улсад банкны салбар байгуулах тухай банкны дүрэмд заасан эрх бүхий этгээдийн тогтоол, шийдвэр;

3.2.3.банкны салбарын удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилсон тухай банкны дүрэмд заасан эрх бүхий этгээдийн тогтоол, шийдвэр;

3.2.4.банкны салбарын удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийн энэ журмын Хавсралт 1-ийн дагуу гаргасан тодорхойлолт;

3.2.5.банкны салбар байгуулах эдийн засгийн үндэслэл, бизнес төлөвлөгөө.

3.3.Монголбанк энэ журмын хэрэгжилтийг хангахад шаардлагатай бусад баримт бичиг, мэдээ, мэдээлэл шаардаж болно.

## **ДӨРӨВ.ТАЙЛАГНАЛ, ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА**

4.1.Банк банкны салбарын өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний тайланг энэ журмын Хавсралт 2-ын дагуу улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 05-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хувилбараар Монголбанканд ирүүлнэ

4.2.Монголбанк шаардлагатай тохиолдолд банкны салбарын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж болно.

4.3.Монголбанк энэ журмын биелэлтэд хяналт тавьж, Банкны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Банкны салбар байгуулах зөвшөөрлийн нөхцөл,  
шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журмын 1 дүгээр хавсралт

..... **БАНКНЫ**  
**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

<b>ТОМИЛОГДОХ АЛБАН ТУШААЛ</b>				
<i>(томилогдох албан тушаалын нэрийг энд бичнэ үү)</i>				
<b>I. Товч танилцуулга</b>				
Ургийн овог:		цээж зураг		
Овог:				
Нэр:				
Төрсөн огноо:				
Регистрийн дугаар:				
Иргэншил:				
Оршин суугаа хаяг:				
Цахим шуудангийн хаяг:				
Утасны дугаар:				
<b>II. Боловсрол</b> <i>(боловсролын гэрчилгээний хуулбарыг хавсаргана уу)</i>				
Боловсрол	Эзэмшсэн боловсрол/ хамгаалсан цол	Суралцсан хугацаа	Сургуулийн нэр	Улс, хотын нэр
...				
...				
<b>III. Ажил эрхлэлт</b>				
Одоо ажиллаж байгаа байгууллага				
Албан тушаалын нэр				
Албан тушаалд томилогдсон огноо				
Ажлын чиг үүрэг				
Ажлын хаяг, утасны дугаар				
Өмнөх хугацаанд ажилласан байгууллага	Албан тушаалын нэр	Ажлын чиг үүрэг	Албан тушаалд томилогдсон огноо	Ажлаас гарсан огноо, шалтгаан
...				
...				
Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бол доорх хүснэгтийг бөглөнө үү.				
д/д	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Улсын дугаар	бүртгэлийн	Регистрийн дугаар
1				
2				
...				
Хуулийн этгээд, банкны хувьцаа эзэмшдэг бол доорх хүснэгтийг бөглөнө үү.				
	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын дугаар,	бүртгэлийн Регистрийн дугаар

1			
...			
<b>IV. Гэр бүлийн байдал</b> ( <i>гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагчийн мэдээллийг оруулна уу</i> )			
	Овог, Регистрийн дугаар	нэр, Таны юу болох	Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал
1			
...			

Иргэний үнэмлэх/паспортын хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

(гарын үсэг)

..... оны ..... сарын .....-ний өдөр

Банкны салбар байгуулах зөвшөөрлийн нөхцөл,  
шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журмын 2 дугаар хавсралт

..... **БАНКНЫ САЛБАРЫН ӨӨРЧЛӨЛТ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЙЛАН**  
..... оны ..... сарын .....-ний өдрийн байдлаар

Банкны салбарын тоо (өмнөх улирал)			Өөрчлөлт (+,-)			Банкны салбарын тоо (тайлант улирал)		
Улаанбаатар хот дахь	Орон нутгийн	Гадаад улс дахь	Улаанбаатар хот дахь	Орон нутгийн	Гадаад улс дахь	Улаанбаатар хот дахь	Орон нутгийн	Гадаад улс дахь

**Шинээр байгуулсан банкны салбар**

Д/д	Банкны салбарын нэр	Банкны шийдвэр, огноо	Байгуулсан огноо	Хаяг
1				
...				

**Байршлыг өөрчилсөн банкны салбар**

Д/д	Банкны салбарын нэр	Банкны шийдвэр, огноо	Байршил өөрчилсөн огноо	Өмнөх хаяг	Өөрчлөгдсөн хаяг
1					
...					

**Өөрчлөн байгуулсан банкны салбар**

Д/д	Банкны салбарын нэр	Банкны шийдвэр, огноо	Өөрчлөн байгуулсан огноо	Хаяг
1				
...				

**Татан буулгасан банкны салбар**

Д/д	Банкны салбарын нэр	Банкны шийдвэр, огноо	Татан буулгасан огноо	Хаяг
1				
...				